

МОНГОЛ ТӨРИЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛ ЯВЦ ДАХЬ АРДЧИЛЛЫН ИЛРЭЛҮҮД

Ч.Баатар

Удирдлагын академийн Нийгмийн салбарын удирдлагын профессорын баг

Германы философич Г.Гегель: “Төр бол өөрийн хувийн оршин тогтнол бүхий жич, онцгой мөн чанар¹³⁸” гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Үүнээс үүдэн төр бол аливаа нэг иргэнээс чухал гэсэн ойлголт бий болсон. Энэ нь төрийг шүтэх үзлийн төлөвших нэг томоохон алхам байв. Ийнхүү шүтэх явдал нь улс төрийн философийг төрүүлсэн гэсэн ойлголт орчин үеийн улс төрийн философийн онолын болон судалгааны бүтээлүүдэд олонтаа тааралддаг.

Улс төрийн философи нь “төр” юмуу “салшгүй эрхүүд” нэр томъёог задлан шинжлэхдээ нийгмийн шинжлэх ухаан болон ёс зүйн онолуудтай бүрэн адилтган үзэж үл болох бие даасан онцгой салбар ухаан гэж хэлж болно¹³⁹.

Нийгэмд төрийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг ОХУ-ын философич Академич Э.А.Поздняков өөрийн бүтээлдээ: “Төр бол зохиомол зүйл биш нийгмийн түүхийн тодорхой үе шатанд үүссэн өөрийн бүтээгдэхүүн гэсэн үзэл баримтлал түгээмэл байдаг. Тэрээр нийгэм дэх материаллаг баялагыг зүй зохистой хуваарилах, хувийн өмчийг баталгаажуулах, нийгмийн дотор ангийн ялгаа гарах, тэдний хооронд зарим төрлийн зөрчил үүссэн нь төрийг бий болгох урьдач нөхцөл болсон”¹⁴⁰ гэж дурьдсан байдаг.

Төрийг түүхийн аль ч үед нийгмийн давхраажилтын дээд хэсгийнхний эрх ашгийг хамгаалсан зэвсэг гэж үзсээр ирсэн. Гэвч орчин үед нийгмийн аль нэг хэсгийнхний эрх ашгийг бусдынхаас дээгүүр тавьж болохгүй бөгөөд тухайн нийгэм, улс орны хөгжил нь ямар төртэй байгаа эсэхээс шууд хамааралтай байдаг гэдгийг онолын хувьд нотолсон. Энэ үүднээс төр өөртөө урьд өмнө төдийлөн хамааралгүй байсан олон зүйлсийг өөртөө хамаатуулах шаардлагатай болж буй мэт боловч ард иргэдийн оролцоонд тулгуурлах зарчмын үүднээс харин ч нийгмийн хөгжлийн үйл явцад оролцох оролцоо нь багасаж буйг судалгааны олон эх сурвалжуудад дурьдсан байдаг.

Нийгмийн хөгжлийн түүхийг бүхэлд нь авч үзвэл төр, иргэн хоёрын харилцан шүтэлцээ гэж хэлж болохоор байдаг. Нийгэм дэхь төр ба иргэний хоорондын харилцаанд заавал байдаг, байсаар ирсэн нэг асуудал нь хүмүүс ямагт төртэй байхыг хүсэж, түүнийг байгуулж, түүгээр үйлчлүүлж ирсэн явдал юм. Зарим үед ард түмэн төртэйгээ зөрчилд орж түүнийг унагааж байсан боловч дахин дахин шинээр байгуулж, нийгэмд төр заавал байх ёстой гэсэн байр сууринаас хандаж байжээ. Энэ үүднээс ард түмэн төрөөс байнга ямар нэгэн юмыг хүсэн хүлээдэг юм гэсэн ойлголтыг бий болгодог. Төрөөс ард түмэн юуг хүсэн хүлээдэг тухай асуудал нь эргээд олон түмний хүсэл эрмэлзэл, бодол санааг гүнзгий судлахыг шаарддаг.

¹³⁸ Гегель Г, Энциклопедия философских наук, М., 1975, стр 73

¹³⁹ Поздняков Э.А, Улс төрийн философи, Улаанбаатар, 2004, 97 –р тал

¹⁴⁰ Мөн тэнд, 103 – р тал

Төр нь ерөнхий утгаараа нэгтгэгч, тодорхой нэг нийгмийн хэв маяг, хөгжлийн загварыг төлөвшүүлэгч байдгаараа нийгмийн түүхэн хөгжлийн бүрэлдүүлэгч үндсэн хүчин зүйл болдог. Нөгөө талаас тухайн үндэстний соёл иргэншлийг бий болгогч үндэс суурь нь болж өгдөг. Мөн тухайн улс, үндэстний зан үйл, ёс заншил, соёлд тэрхүү төрийн онцлог нягт шингэсэн байдаг.

Монголчуудын философи сэтгэлгээн дэх төрийн тухай ойлголт нь анх Монгол газар нутагт төвлөрсөн төрт улс бий болж бүрэлдсэн буюу Хүннү гүрний үеэс боловсрон уламжлагдсаар Чингис хааны үндэслэсэн Их Монгол улсын үед нилээд боловсронгуй болж, өөрийн онцлог шинж төрхөө бүрэн олсон гэж хэлж болно. Судалгааны эх сурвалжуудаас¹⁴¹ үзэхэд Монгол төрийн зарим онцлог шинжүүдийг дараах байдлаар нэгтгэн дүгнэж болно. Үүнд:

- ✓ Төрийн эрх мэдлийн уг сурвалж буюу легитимт шинж чанар нь тэнгэр шүтэх үзлээр нөхцөлдсөн байдаг.
- ✓ Ард иргэдийн ертөнцийг үзэх үзэл, зан үйл, ёс заншил, соёлд улсыг эрхэмлэх үзэл давамгайлсан шинж харагддаг.
- ✓ Төрийн зохион байгуулалтад тэнгэрийг шүтэх үзэл, арга билгийн ёсыг харгалзан үзсэн байдал зэргийг юуны өмнө дурьдаж болно.

Монгол төрийн эрх мэдлийн уг сурвалжийн тухай асуудал нь хаан, толгойлогч нарын тэнгэр гарлаар тайлбарлагддаг тухай олон бүтээлд дэлгэрэнгүй дурьдсан байдаг.

Улсын тухай Монголчуудын төсөөлөл нь юуны өмнө түүнийг өрх гэртэй адилтгах явдал юм. Тиймээс ч “улс гэр” гэх мэт хэллэг, “гэрээ засаад төрөө зас” гэх мэт зүйр цэцэн үг гарсан байдаг. Тиймээс төрийн тэргүүн болох хаанаа улс гэрийн эзэн гэж үзэх үзэл, нөгөө талаас “эцэг тэнгэр”-ийн тухай үзэл нийлэн улс гэрийн эзэн болсон хаан хүний тэнгэр гарлын тухай итгэл үнэмшлийг бий болгосон гэж үзэж болно.

Тэнгэр эцэг, газар эхийн тухай болон хаадын тэнгэр гарлын тухай олон бүтээлээс үзэхэд хаадын тэнгэр язгуурын тухай үзэл нь бөөгийн шашны ертөнцийг үзэх үзэлд үндэслэсэн гэж үзэж болохоор байдаг. Өмнө хийгдэж байсан судалгааны эх сурвалжуудаас үзэхэд төрийн тухай энэхүү үзэл нь Монголчуудын нийгмийн ухамсарт баттай шингэсэн болох нь харагддаг. Тиймд төр бол нийгмийн дээд талд байдаг, нийгмийг дарангуйлж байдаг хүчирхийллийн бүрдэл, мөн ангийн ноёрхолын зэвсэг, түүнчлэн төр, иргэний нийгэм гэж ялгаварлах үзэл Монголчуудын философи сэтгэлгээнд төдийлөн дэлгэрээгүй байна.

Монголчуудын түүхэн хөгжлийн үйл явцад хаан ширээг булаалцалдаж хаан язгуурынхан, хааны угсааны бус язгууртнууд хоорондоо тэмцэж байсан тохиолдол олон байдаг. Гэвч жирийн ард иргэдийн дотроос хаан ширээний төлөө тэмцэн бослого, үймээн, төрийн эргэлт хийх гэж оролдож байсан тохиолдол тун ховор юм.

¹⁴¹ Энэ талаар судлаач Гонгор Д, Жүгдэр Ч, Ринчен Б, Нацагдорж Ш, Хавх Н, Чулуунбаатар Г, Ганхуяг Ш, Гантөмөр Б, нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзэж болно.

Монголын философи сэтгэлгээнд төр, иргэн хоёрын салшгүй холбоо, шүтэлцээнд улс оршино гэж үзэх үзэл давамгайлах хандлага ажиглагддаг. Энэ нь иргэн юуны өмнө төрдөө хандаж аврал, шударга ёсыг хүсдэг нь үүнтэй холбоотой юм.

Монголчуудын төрдөө хэрхэн ханддаг байсны сэтгэлгээний нэг тод илрэлийг бэлэгдлийн ёс заншлаас нь харж болно. Тухайлбал, "бурхан өршөө" гэдэгтэй нэг зиндаанд тавьж "төрийн сүлд минь өршөө" хэмээн залбирдаг. Энэ нь Монголчуудын хувьд төр бол бурхантай адил хүчтэй, ивээл хайрандаа иргэдээ багтаадаг шүтээн нь байсныг илэрхийлж байна. Мөн төрийнхөө сайн сайхныг, нөгөө талаас үр хүүхдийн хувь заяаг эрхэмлэн ерөөж төр гэсэн үг багтаасан нэрийг түгээмэл өгдөг нь бусад үндэстэн угсаатанд төдийлөн их тааралддаггүй уламжлал юм. Монголчууд бэлэгдлийг эрхэмлэн үздэг сэтгэлгээнийхээ үүднээс төрсөн үрийн адилаар төрдөө хайртай байдгийг болон нөгөөтэйгүүр төр маань бат, мөнх, энх, төвшин, тогтвортой байгаасай гэдэг үүднээс чин эрмэлзэлээ шингээж хүүхдээ тэрхүү бат, мөнх, энх, төвшин, тогтвортой төр шиг байгаасай гэж ийм нэрүүдийг сонгодог байна. Энэ нь төрийн билэгдэл бусад үндэстэн угсаатныхаас арай өөр төлөвшсөн гэж үзэх үндэслэл болдог.

Монголчуудын төрийн тухай философи сэтгэлгээ нь ихэвчлэн бодит байдал дээр, тухайлбал нийгмийн хөгжлийн үйл явцтай ихээхэн уялдсан байдаг. Үүнийг тэдгээрийн амьдралын үндсэн хэв маяг болсон нүүдлийн соёл иргэншилтэй нягт уялдаатай гэж үзэж болно. Учир нь философийн судалгаанд соёл иргэншлийг авч үзэхдээ гол төлөв соёлын шинж тэмдгийг гол болгодог. Энд яригдаж байгаа соёл бол нийгмийн бүх гишүүдийн биш гэхэд тэдний олонхийн итгэл, үнэмшил, үйл ажиллагааны нь дадал хэвшил болсон тийм зүйлээс бүрэлдэх соёл юм. Тиймээс төрийн талаарх эрх баригчид хийгээд иргэдийн энгийн ухамсарт шингэсэн тэр л ойлголт соёл иргэншлийн онцлогийг илэрхийлдэг байна.

Төр, иргэний салшгүй холбоо, харилцан үүрэг хүлээх тухай үзэл санаа Монголчуудын дотор эртнээс уламжлалтай юм. Төрийн хүлээх үүрэг бол Монголын нууц товчоонд тодорхойлсноор: Иргэдийг "хөлийг нь хөсөр, гарыг нь газар тавиулж" жаргуулах явдал болно. Түүнээс хойш олон зуун жил өнгөрсөн боловч энэ ойлголт хэвээрээ уламжлагдаж ирснийг 1919 онд Сэцэн хан аймгийн Хурц ван Түвдэнгийн хошууны 75 хүн мөнхүү ван Түвдэнтэй заргалдсан бичгээс үзэж болно. Тэнд: "Эдүгээ манай засаг ван хошууг захиран алба хэргийг шийтгэснээс хойш, дорд олныг асарч өрнүүлэн хүмүүжүүлэхийг бодохгүй, өөрийн биеийг их зэрэг тушаалд хүргэхийг бодох зэргээр хаа буй газар бүрийн иргэн Монголчуудад ихэмсэг өр хийж, . . . чухал албыг гэж битүүлэн ноогдуулан цөлмөн хамж онц хохируулан" буй хэмээн дурьджээ.¹⁴² Ийнхүү өргөдөл бичигчийн ойлголтоор төрийн үүрэг бол иргэдийг асарч өрнүүлэн хүмүүжүүлэх явдал болно. Энэхүү томъёолол нь гэр бүл дэхь эцгийн үүрэгтэй зарим үед давхцах тохиолдол ч байдаг.

¹⁴² Ардын заргын бичиг, Улаанбаатар, 1966, 195 – р тал

Бөөгийн шашны ертөнцийг үзэх үзлийн дагуу тэнгэр эцгийн газар дээрх биелэл болсон өрх гэрийн болон улс гэрийн тэргүүний үүрэг ийнхүү адил байх нь тухайн үзэл баримтлалын үүднээс зүйн хэрэг болно. Харин Монголын түүхэн хөгжлийн аль цаг үед ард иргэдийн зүгээс төрдөө үнэнч байх нь чухал байсаар иржээ.

XIII зууны үед энэ үзэл хаанд ч, түүний угсааны хийгээд бус язгууртнуудад ч, жирийн иргэдэд ч хөдлөшгүй хууль болон ойлгогдож байсан байна. Тухайлбал, Монголын нууц товчоонд дурьдсанаар Наяа жанжин, Ширээт өвгөн, өөрийн дүү Алаг нарын хамт өөрийн эзэн Таргудай Хирултигийг барин авч Чингис хаанд хүргэх гэснээ: “Бид энэ Таргудайг барьж очвол Чингис хаан биднийг хан эзнээ барьж ирсэн итгэмжгүй ард гэж биднийг итгэж нөхөрлөхгүй, харин хан эзэндээ халдсан харц ард гэж барьж алах биз”¹⁴³ гэж бусдыгаа ятган Таргудайг тавьж явуулан Чингис хаанд очдог. Чингис хаан Наяаг эцгийн хамт өршөөн харин Жамухыг барьж ирсэн хүмүүсийн цаазалдаг. Түүгээр үл барам Чингис хожим хүмүүсийн гавьяа зүтгэлийг нь үнэлэн албанд томилохдоо Наяагийн энэхүү үйлдлыг дурьдаад “хаанаа хайрлах их ёсыг мэдсэн хүн”¹⁴⁴ гэж үнэлэн төвийн түмний ноён болгодог. Монголын энэхүү ёс бүр эртний уламжлалтай болохыг зарим судлаачдын бүтээлээс тод харж болно.

Энэ үеийн төрийн засаглалын тухай дундад Азийн түүхч Рашид ад дин өөрийн алдарт бүтээл “Судрын чуулган”-даа: “Өгөөдэй хаан болсныхоо дараа Цагаадай хаантай хамт явж байжээ. Архинд нэлээд согтсон Цагаадай хаан хоёулаа мөрий тавьж уралдая гэж Өгөөдэй хаанд хэлжээ. Цагаадай хааны морь илүү түргэн хөлтэй тул Өгөөдэй хааны мориноос толгой түрүүлэн давхисан байна. Шөнө нь Цагаадай хаан гэртээ өдрийн болсон үйл явдлаа эргэцүүлэн бодоод би хаантай мөрийцөөд уралдаж байдаг, тэгээд миний морь түрүүлчихдэг. Үгүй ер ийм бүдүүлэг ёс бус юм гарах гэж. Үүнийг үзэж сонссон хүмүүс юу гэж бодох вэ? Энэ ер нь тун хортой муу уршигт хүргэнэ гэж эргэцүүлжээ. Тэгээд Цагаадай хаан өглөө эрт босон ноёдоо дуудан хэлсэн нь: Өчигдөр би нүгэлтэй юм хийчихлээ гээд болсон үйл явдлаа ярьжээ. Одоо өндөр дээд хаантан луу очье надад зохих шийтгэлийг нь оноовол оноог гэжээ. Цагаадай хаан ноёдтойгоо хааны ордон руу тогтоосон цагаас өмнө явжээ. Цагаадай хаан өгүүлсэн нь: Бид хоёр төрсөн ах дүү хоёр. Саяхан хуралдай дээр Өгөөдэйг ятгаж хаан болгоод, бид түүнд захирагдаж зарлигийг нь дагахаар тангараг тавьсан. Бид ямар тохиолдолд түүнийг эсэргүүцэхгүй, түүнтэй маргах учиргүй. Өчигдөр би түүнтэй мөрий тавиад морио уралдуулсан юм. Бид хаантайгаа мөрий тавиад уралдах ёстой гэж үү? Ийм учраас би гэмтэн мөн. Би ингээд өөрийхөө гэмийг мэдээд шийтгүүлбэл таарна гэж ирлээ. Намайг албал алтугай, ташуурдвал ташуурдтугай, хаантан өөрөө шүүг гэжээ. Өгөөдэй хаан: Энэ чинь юу гэсэн үг вэ? Тэр чинь миний том ах. Ийм жижиг юмны төлөө санаа зовоод хэрэггүй гэжээ. Цагаадай хаан эхлээд Өгөөдэй хааны хэлснийг зөвшөөрсөнгүй. Сүүлдээ хаан түүний амийг өршөөсөн гэдгийг зөвшөөрч хойшид

¹⁴³ Монголын нууц товчоо, Улаанбаатар, 1966, 108-р тал

¹⁴⁴ Монголын нууц товчоо, Улаанбаатар, 1966, 192 тал

үнэнч зүтгэхээ илэрхийлж есөн морио өргөн барьсан байна¹⁴⁵” Эндээс үзэхэд тухайн үеийн нийгмийн хэв маягыг бүрдүүлсэн төрийн үндсэн шинж нь төр нь иргэнээ асарч өргөх, иргэн нь төрөө хүндэтгэх үзэл байсан бөгөөд энэ нь Монголын философи сэтгэлгээн дэх төрийг үзэх үзлийн нэг онцлог гэж хэлж болох юм.

Монголчуудын философи сэтгэлгээн дэх төртэй адил утгаар ойлгогддог зүйл бол улс хэмээх ойлголт юм. Монголчууд энэ хоёр ойлголтыг улс төр хэмээн хослуулан хэрэглэх элбэг байдаг. Улсын тухай ойлголт нь Монголчуудын хувьд хувь хүн, нийгэм хоёрын, нөгөө талаас нэгж, нийтлэг хоёрын харилцан шүтэлцээ болох нь илрэн харагддаг. Тодруулбал, Монголчууд иргэн, төр, улс гурвыг нягт холбоотойгоор авч үзжээ.

Өрнө дахины сэтгэлгээнд хувь хүнийг онцлох тал нь арай илүү байдаг. Христос бурханы өмнө бүгд тэгш, ертөнцийн эзний үгийг хүн бүр өөрөө тайлбарлан ойлгох эрхтэй гэх мэт орчин үеийн улс төрийн философиос өмнөх үеийн зарим үндэслэлүүд энэхүү үзлийн эх үндэс болсон байдаг. Гэтэл Монголчууд бүр цаашлаад дорно дахины ихэнхи үндэстнүүдийн хувьд нийгэм буюу нийтлэгийн чухалчлах тал нь арай илүү гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, Монгол хүний хувьд тухайн хүн хэн байх нь төдийлөн чухал бус, харин нийгмийн аль түвшинд, хаана хамаардаг нь чухал ажээ.

Энэхүү байдал нь Монгол хүний хувьд удам угсаа, гэр бүл, нутаг усаа чухалчлах сэтгэлгээг үүсгэдэг. Энэ нь одоо ч хадгалагдан үлдсэн байна. Монгол хүн өөрийгөө удам судар, эцэг эх, нутаг ус, эх орноосоо хэзээ ч салангид авч үздэггүй. Тухайлбал, зах зээлийн харилцаанд шилжиж хүмүүс хувийн аж ахуй байгуулах бололцоо нээгдсэний дараа бий болсон олон аж ахуйн нэгжийг тэдгээрийг үүсгэн байгуулагчид өөрсдийн өсөж төрсөн газрын нэрээр нэрлэсэн байдаг нь үүнийг нотолж байна.

Монголчуудад эртнээс эдүгээг хүртэл өөрийгөө нийтлэгийн нэг хэсэг гэж үзэх сэтгэлгээ хүчтэй байсаар байгаа болно. Энэхүү сэтгэлгээний нэг илрэл бол улсын тухай үзэл юм. Монголчуудад төрөөс гадна улс чухал юм. Улс бол зүгээр олон хүн биш байдаг. Түүнийг байгуулдаг, өөрөөр хэлбэл энэ нь бие даасан цогц мөн ажээ. Улсын тухай ойлголт нь овог аймгийн тухай ойлголтоос өөр юм. Овог аймаг нь гол төлөв цусан төрлийн хэлхээ холбоон дээр тогтож байв. Гэтэл улс бол хүн амаас гадна газар нутгийн үзэл баримтлал бий болдог байна. Энд жишээ болгож Хүннү улсын анхны шанью Модуны хэлсэн: “Газар бол улсын үндэс мөн” гэсэн үгийг дурьдаж болно. Тэрээр ийнхүү Монголчуудын дунд ийм домог яригдаж энэхүү үгийг сайшаасан санаа нь тэдний улс төрийн философийн үндэс болсон хамгийн чухал явдал болно.

Улс хэмээх цогц ойлголт нь Монгол газар нутагт хоёр мянга гаруй жил оршин тогтнож хүмүүс өөрсдийгөө аль нэг улсад хамааруулан үздэг уламжлал баттай тогтсон. Улс бол төртэй, ард түмэнтэй, газар нутагтай цогцолбор ойлголт. Тиймээс ч улс, төр, иргэн гурав ижил, тэнцүү гэж болно. Аль нэгнийг нь орхигдуулбал улс ч улс биш, төр ч төр биш, иргэн ч иргэн биш болно. Энэхүү

¹⁴⁵ Рашид ад дин, Судрын чуулган, Улаанбаатар, 1998, 19 тал (Х.Ширчингийн орчуулга)

үндэслэл одоо цагт ч нэн чухал хэвээрээ л байгаа юм. Энэхүү сэтгэлгээнд л Монгол төрийн төлөвшилтийн үйл явц, түүний мөн чанар, төр иргэний харилцан хамаарал оршино.

Монголчуудын дээрх уламжлалтай нягт холбогдох зүйл бол төрийн шийдвэр гаргах арга мөн. Монгол төр тусгаар байсан бүх түүхэндээ чухал шийдвэрийг нийтээр хэлэлцэн гаргах ёсыг баримталж байжээ. Тухайн үеийн нөхцөл байдал, эрх баригчдын араншин зэрэг олон зүйлээс шалтгаалж хэрэгжилт нь янз бүр байсан боловч эртний эе эв, их Монгол улсын үеийн *их хуралдай*, Богд хаант Монгол улсын үеийн *улсын хурал* зэрэг нь Монгол төрийн энэ уламжлалыг ямар нэг хэмжээгээр дагаж байсны илэрхийлэл мөн. Үүнийг зөвхөн овог аймгийн үеийн үлдэгдэл гэж үзэж болохгүй.

Монгол төрийн зарим нэг шинж нь газар нутаг, амьдралын хэв маягаас үүдэн гарсан байдаг. Том хэмжээтэй газар нутаг дээр таруу сийрэг суурьшсан, харьцангуй чөлөөтэй амьдрал бүхий Монголчуудыг нэгэн удирдлагад оруулах хамгийн шилдэг арга бол хамтын шийдвэр гаргаж түүнийгээ дагах явдал байлаа. Тэгэхдээ энэхүү түүхэн үйл явцыг хэт эдүгээчилж өнөөгийн ардчилсан нийгмийн шинж бүр Чингис хааны үед байсан гэх мэтээр үзэж болохгүй. Ийнхүү хамтын шийдвэр гаргадаг байсан нь тал нутгийн нүүдэлчидийн аж төрөх ёс, Монгол сэтгэлгээнд тулгуурласан төрийн өвөрмөц шинж юм.

Өрнө дахины ардчилалд тулгуурласан суурь зарчим бол тэгш эрхийн зарчим байдаг. Гэтэл Монгол төрийн дээрх түүхэн уламжлал нь шийдвэрийг оновчтой гаргах шилдэг аргыг сонгон хэрэглэх хэрэгцээнээс үүдэлтэй гэж болно.

Монгол төрийн уламжлал, өөр нэг онцлог шинжийн нэг бол түүний бүтэц зохион байгуулалтын өвөрмөц байдал юм. Ихэнх философичид Монгол төрийн бүтэц зохион байгуулалт нь Монголчуудын уугуул ертөнцийг үзэх үзлийн номлолд тулгуурлаж байсан гэж үздэг. Энэхүү бүтэц зохион байгуулалт нь өөрийн гэсэн өвөрмөц үзэл баримтлал, номлолд суурилдаг. Энэхүү номлолын хэрэгжилт нийгмийг зохион байгуулах нэн цомхон бүтэц болох удирдлагын аравтын тогтолцоонд суурилсан төрийн байгууламж юм.

Ертөнцийг үзэх бөөгийн үзлээр аравтын тогтолцоо нь хүний биеэ мэдэн авч явах хамгийн зохистой хэмжээ хэмээдэг. Үүний философийн томъёолол нь: Би болон есөн үе, өөрөөр хэлбэл тэнгэрийн тоо буюу ертөнцийн хамгийн их тоо ес ба ертөнцийн хамгийн бага тоо нэг буюу хэмээсэн байдаг. Тодруулбал, нэгэнт ес бүхний дээд хязгаар юм бол хүний үйл ажиллагаа түүнээс давж хэрхэвч үл чадна. Мөн нэг нь хамгийн бага тоо буюу хүний бүхий л үйл ажиллагаа нь эхнээсээ эхэлдэг хэмээн бэлэгдсэн хэмээдэг.

Эндээс үзвэл удирдлагын аравтын тогтолцоо нь нийгмийг хүнчлэн төсөөлсний үр дүнд, өөрөөр хэлбэл нэг хүний бусадтай адил тэгш, зэрэг харилцах, эсвэл өөрийн үйл ажиллагаанд хяналт тогтоох зүй зохистой хэмжээнд барьж чадах дээд хязгаарыг илэрхийлсэн бэлэгдлийн шинжтэй хэмээн үзэж болно. Мөн үүнийг энгийн ойлголтын үүднээс авч үзвэл: "Хүн хичнээн төгс оюун ухаан, эрдэм мэдлэг, хүч чадалтай байвч есөөс дээш хүнийг бүрэн хараа хяналтандаа байлгаж хэрхэвч чадахгүй гэж үзсэнтэй холбоотой гэж ойлгож

болно. Энэ нь зуутын эсвэл мянгатын ноён гэх мэт нь зуун хүнийг, эсвэл мянган хүнийг бус зөвхөн чухам арван аравт нэгэн зуут, арван зуут нэгэн мянгат болох учраас аравтын эсвэл зуутын арван захирагчаас нэгэн нь үлдэх есөн захирагчаа шууд удирдана¹⁴⁶” гэсэн үг байна.

Энэхүү аравтын тогтолцоо нь эртний Хүннү улсаас улбаалан Их Монгол улс хүртэл уламжлан ирсэн. Их Монгол улсын үед энэхүү төрийн зохион байгуулалтыг улам нарийсган захирах, захирагдах ёс, тайлагнах, сахилга сахих ёс зэрэг олон зүйлээр баяжуулсан байна.

Төрийн шинжтэй холбоотой нэг чухал асуудал бол нийгмийн шинж байдаг. Монголын нийгмийн хөгжлийн ерөнхий үйл явцаас харахад түүхийн бүхий үйл явцынхаа туршид нийгмийн шатлалт шинжийг агуулж байсан бөгөөд түүгээрээ нийгэм ба хувь хүний харьцаа нь тодорхойлогдож байсан юм. Гэхдээ энэ нь орчин үеийн шинжлэх ухааны үүднээс тухайн нийгэм дотор эрчимтэй социаль хөдөлгөөн байгаагүй хэмээн ойлгож болохгүй юм. Өвөрмонголын эрдэмтэн Лувсанчойдонгийн дурьдсанаар: “Цэрэг эр зориг үзүүлэн гавьяа байгуулбал дээд язгуурт шилжиж болдог. Хулгай хийх, худал хэлэх зэргээр муу явбал доод язгуур шилжиж болдог ажээ¹⁴⁷” хэмээсэн байна.

Монголын төрийн бас нэг онцлог шинж бол түүний нээлттэй байдал юм. Монголчууд мал аж ахуй эрхлэн амьдардаг, амьдралын хэрэгцээгээ хангахын тулд заавал гадагшаа харилцах шаардлага бусад улс үндэстэнээс илүү байдаг нь ийм нээлттэй байх үндсийг бүрдүүлдэг гэж хэлж болно. Их Монгол улсын үед элч төлөөлөгчдийг хүндэтгэдэг, улс хоорондын худалдаа, дипломат үйл ажиллагаанд их анхаарал тавьдаг байсан. Тэрчлэн янз бүрийн шашинг ялгаварладаггүй, тэгэхдээ аль нэгийг нь онцгой эрх эдлэхийг нь хориглодог¹⁴⁸ байсан нь тухайн үедээ тун шинэлэг санаа байв. Энэ нь тэр үед Монгол улс бол дэлхийн улс мөн¹⁴⁹ хэмээн үзэж байсан нь зохих хэмжээгээр нөлөөлсөн байх талтай юм. Нэгэнт дэлхийн улс гэж ойлгогдож байсан болохоор хаах, хязгаарлах тухай санаа төрөхгүй байсан хэнд ойлгомжтой байна. Энэ нь Монгол төрийн үйл ажиллагааны үндэслэгээ болсон философи сэтгэлгээнд орчин үеийн нээлттэй нийгмийн үзэл баримтлалын үр хөврөл бага хэмжээгээр ч болов агуулагдаж байсныг илэрхийлдэг.

Монгол улсын түүхэн хөгжлийн үйл талаас харвал Монгол төр нь өөрийн гэсэн өвөрмөц соёл иргэншил бүхий нийгэмд бүрэлдэн төлөвшиж, түүнийхээ нэг салшгүй хэсэг болсоор иржээ. Монгол төр нь өөрийн үйл ажиллагаагаараа Монголын нийгмийн ерөнхий хэв маягыг бүрэлдүүлсэн гэх бүрэн үндэстэй юм.

Монгол төрийн төлөвшлийн гол үндэслэлүүд бүр Хүннү улсын үеэс эхлэн үүсэж Хүннү болон түүний дараа оршин тогтнож байсан төр улсуудын туршлагаар хөгжин батжиж ирснийг Чингис хаан болон түүний залгамжлагчид улам төгөлдөржүүлэн хөгжүүлсэн гэж хэлж болно.

¹⁴⁶ Монголын философийн түүх, Улаанбаатар, 1997, 96-р тал

¹⁴⁷ Лувсанчойдон, Монгол зан үйлийн ойлбор, Хөх хот, 1981, 39-43-р тал

¹⁴⁸ Их засаг хууль, 43-р зүйл

¹⁴⁹ Их засаг хууль, 30-р зүйл

Академич Ч.Жүгдэрийн нэгэн бүтээлд бичсэнчлэн: “Чингис хааны төр ёсны үзэл түүнд тулгуурласан төрийн байгуулалтын хүрээн дэх үйл ажиллагаа нь Монголын нэгдсэн тулгар төрийг байгуулж, түүний түүхэн үүрэг ач холбогдлыг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийг өмнөх төрүүдээс улам нарийсган, хууль цаазыг бий болгон мөрдүүлж, үлгэр жишээ болохуйц цэрэг, арми байгуулан бэхжүүлж, хатуу чанга сахилга бат тогтоож, төрийг байнга хайрлан бэхжүүлэхийн чухлыг бүх талаар үндэслэжээ”¹⁵⁰ гэсэн байна.

Чингис хаан болон түүнийг залгамжлагчдын үйл ажиллагаанд арга билгийн ёс, аливаа зүйлийн хэр хэмжээг зүй ёсонд нийцүүлэх, үйл ажиллагаа төрийн ёсоор үндэслэх зарчим мөрдөгдөж байсан байна. Тухайлбал, Чингис хааны үеэс баримталж эхэлсэн “Мориноосоо буулгүй улс орныг эзлэх амар, мориноосоо буугаад улсыг удирдах хэцүү”, “Морин дэл дээр байгуулсан улсыг мориноос буулгүй удирдаж болохгүй” гэх зэрэг зарчмууд нь цөм л арга билгийн ёсны үзэл санааг илэрхийлсэн байдаг. Хожим Хубилай хаан дээрхи үзлийг үндэс болгосон боловч тухайн түүхэн нөхцөл байдалдаа тааруулан өөрчилсөн “Хятад хүнийг хятадын хуулиар”, “Монгол хүнийг монголын хуулиар” гэдэг зарчим болон шашин, төрийг хослон барих хоёр ёсны үзэл зэрэг нь янз бүрийн нөхцөл дэх Монгол төрийн үндсэн үзэл баримтлалын илрэл болно.

Нэлээд хожуу үеийн Монголын философич В.Инжинашийн бичсэнээс үзвэл: “Чингис хаан Алтан улс нь төрийн хүнд эрхийг цөм бичгийн сайдад бариулснаар төр нь цэргийн эрдэм бүхий хүнгүй болж мөхөхөд хүрсэн”¹⁵¹ гэж шүүмжлэн өгүүлж байжээ. Өөрөөр хэлбэл Алтан улсын төрийн удирдлага билгийг гол болгож, аргыг орхигдуулснаас болж буруудсан тухай өгүүлжээ. Мөн “Хөх судар”-т цагаан сараар хэтэрхий их ёслол хийхийг шүүмжлэн: “Дээл ихэдвээс өмссөн хүний биед ачаа болно. Эмээл хүндэдвээс тохсон морины нуруунд дарамт болно. Эрхэм хэтэрвээс хүний сэтгэлд осолдох болно. Янз хэтэрвээс эл улсын дордод зүдгүүр болно” хэмээсэн байдаг.

Их засаг хуулинд ноёд ихэс, түүний дотор алтан ургийнхныг хүртэл нэрний нь өмнө зөвхөн албан тушаалыг хэлж дуудах ба өөр алдар, чимэг зүүхийг хориглосон заалт байдаг. Энэ бүхэн бол аливаа зүйлийн хэр хэмжээг тааруулж байх эс тэгвээс төрийн хэрэгт хор учирна гэж үзэж байсны илэрхийлэл юм.

Дорно дахины хийгээд Монголчуудын нийгмийн сэтгэлгээний үүднээс төрийн мөн чанар хийгээд утга нь дараах ойлголтуудад хамаарагддаг байна. Үүнд:

- ✓ Төр нь ер бусын бурханлаг гаралтай зүйл мөн бөгөөд түүнд хүн төрөлхтөнтэй холбоотой зүйл байдаггүй.
- ✓ Гайхамшигтай төгөлдөр, хүчин чадал бүхий зүйл болох төрд тохиолдлын буюу дутагдалтай зүйл байхгүй юм.
- ✓ Засаглалыг хэрэгжүүлэхэд хувь хүний хүчин чадал төдий л хангалттай бус хэмээн үздэг.

¹⁵⁰ Жүгдэр Ч. Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн түүхэн тойм, Улаанбаатар, 2005, 49 тал

¹⁵¹ Инжинаш В. Хөх судар, Тэргүүн дэвтэр, Хөх хот, 1992, 363 - 364-р тал

- ✓ Төр нь хувь хүнийг гол ивээгч нь бөгөөд энэ утгаараа нийгэм дэх хамгийн гол зүйл болдог.
- ✓ Хувь хүний эрх ашиг төрийн эрх ашгийн дэргэд юу ч биш, ер нь төрийн хүсч байгаа зүйлд хувь хүн өөрийн эрх ашгийг зохицуулах ёстой.
- ✓ Хувь хүн төрд зохих хэмжээний үүрэгтэй гэж үзвэл зөвхөн манлайлагчид л тийм байж чадна.
- ✓ Төрд итгэсэн итгэл нь улс төрийн үзлээсээ илүүгээр ёс суртахуунжсан шинжтэй байдаг зэрэг болно.

1990-ээд оноос манай улсад бий болсон мөн ардчиллын төлөвшилтийн үйл явц нь төрийн үйл ажиллагаанаас үүдэн бий болсон нийгмийн бүтцийн асуудалтай ихээхэн холбогддог. Үүнийг Монгол төрийн үйл ажиллагаа хийгээд түүнээс улбаатай нийгмийн бүтэц, зохион байгуулалтын асуудалтай холбон авч үзэх шаардлагатай юм.

Монголын улс төрийн философийн түүхэнд нэлээд ул үндэстэй судлагдсан нэг асуудал бол Монгол төрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх асуудал байдаг. Төрийн тухай асуудлаар өөрийн орны судлаачдын 1990-ээд он хүртэлх үеийн судалгааны эх сурвалжуудаас дараах дүгнэлтүүдийг анхааран үзэх шаардлагатай юм. Үүнд:

- ✓ Монгол хэлэнд төр, улс гэдэг үгсээр илэрхийлэгддэг хоёр өөр ойлголтыг лав л орос, англи хэлэнд нэг үгээр илэрхийлдэг. Үүнтэй холбоотой манай судлаачид европын эрдэмтэдийн судалгааг ашиглахдаа тухай тохиолдолд орос хэлний “государство”, англи хэлний “state” гэдэг үг “төр”, “улс” гэдэг хоёр ойлголтын алиныг нь илэрхийлж байгааг дутуу анхааран хольж хутгах явдал гарч байна.
- ✓ Өрнөдийн философи, улс төрийн шинжлэх ухааны янз бүрийн төлөөлөгчид төрийг өөр өөрөөр тодорхойлон тайлбарладаг бөгөөд тэдгээр тус бүр нийгмийн сэтгэлгээний чухал үр дүн болсон зохистой тал ба туйлшруулга бүхий байдаг.

XIII зуунаас хойшхи үеийн Монголын түүхийн харьцангуй биеэ даасан өөр өөр нөхцөл дэхь төрийн үүрэг, зорилтынх нь зохих ялгааг иш үндэс болгон тодорхойлох шаардлагатай юм. Тэдгээр тодорхойлолтонд багтах зарим гол шинжийг дурьдвал дараах дүгнэлтүүдийг дурьдаж болно. Үүнд:

Нэг. Чингис хааны байгуулсан төр бол Монгол угсааны бүх овог, аймгийг нэгтгэсний үндсэн дээр эзэн хааны алтан ургийнхны улс төрийн ноёрхолыг Монгол даяар хангаж ирсэн хүч, алтан ургийнхан болон Чингис хааны ивээлээр төрсөн бүх ноёд өөр өөрийн эзэмшил нутаг дахь хүн амыг харьяатаа болгох үйл явцыг хуульчлан бататгаж асан албадлагын зохион байгуулалт, Монгол улсын аюулгүй байдлыг хангах хүчин зүйл байжээ.

Хоёр. Их гүрэн тухайлбал, түүний сүүлчийн үе болох Юан улсын төр бол Монгол улсын зүгээс байлдан эзэлсэн бүх улс орноо захиргаандаа барьж байх зэвсэг, эзэн хааны алтан ургынхны зарим гишүүний эрх мэдэл булаацалдсан

тэмцлийг болон ард олны дотор гардаг үймээн самууныг дарах хүч, бас цэрэг дайны бэлтгэлийг найдвартай хангах болон өнчин ядуусыг тэтгэх зэрэгт зориулсан эдийн засгийн тодорхой үйл ажиллагаа явуулдаг байгууллага байсан юм.

Гурав. Монголын улс төрийн бутралын үеийн төрийг тодорхойлохдоо энэ төр улс орныхоо нэгдмэл байдлыг хамгаалагч, манжийн түрэмгийллийг эсэргүүцэгч хүч байсан юм.

Дөрөв. Монгол улсын түүхийн өөр өөр үед төрийн үйл ажиллагааны шинж чанар, зорилтонд тийнхүү зохих ялгаа байсан тулд тэдгээр үе шат бүрийн онцлогынх нь үүднээс Монголын төрийг тодорхойлохдоо төр бол гол үүргийн хувьд ноёрхогч ангиас дарлагдагч олон түмнийг дарангуйлах машин байсан нөхцөл, тохиолдол түүхэнд цөөнгүй дөвийлгөн туйлчлаад зогсохгүй түүхийн тодорхой нөхцөлд түүний гол үүрэг өөр өөр байж болдгийг үгүйсгэдэг хэвшмэл сэтгэлгээнээс салах учиртай.

Монгол улс дахь нүүдлийн соёл иргэншил нь өөрийн гэсэн онцлогтой нөхцөл, өвөрмөц загвараар хөгжиж ирсэн боловч суурин соёл иргэншлийн нэгэн адилаар эцсийн эцэст хүн амын өөрчлөгдөн буй хэрэгцээг хангахад чиглэгдэж иржээ. Монголын нүүдэлчид нь нийгмийн хэрэгцээ, нийгэмд байж болох баялгийн хоорондох харьцааг хамгийн тааламжтай болгох үйл явцыг түүхийнхээ бүхий үйл явцад хэрэгжүүлж ирсэн гэж хэлж болно. Монгол дахь нүүдлийн соёл иргэншил нь адгуусан амьтанг гэрийн болгосон цагаас нүүдлийн мал аж ахуй жинхэнэ утгаараа төлөвших хүртлээ байгаль орчин дасан зохицох үйл явцыг тасралтгүй хэрэгжүүлсээр ирсэн гэж хэлж болно.

Монголын нүүдлийн соёл иргэншлийн үндсэн хэв шинж нь эх газрын эрс тэс уур амьсгалд зохицож ирснээс гадна байгалийн байнгын өөрчлөлт, түүний экологийн үр дагаварт илүү зохицсон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Энэ зохицолт нь Монголын нүүдлийн соёл иргэншил дэх төрийн түүхэн хөгжлийн бодит байдлыг ойлгон судлахад хамгийн гол судалгааны хэрэглэгдэхүүн болох бөгөөд сэрүүн уур амьсгалтай бүсүүдийн суурин нийгэмтэй Монголын нүүдлийн соёл иргэншлийн үйл явцыг махчилан харьцуулж болохгүй гэдэг нь ойлгомжтой.

Экологийн үүднээс хамгийн таарамжтай олон тооны тархай бутархай аж ахуйнууд мал сүргийг нэг төрлөөр дагнахгүй олон талын ашигтай мал аж ахуйн шаардлагын янз бүрийн илрэлүүдтэй хослуулах байдал юм. Гэхдээ хүн амын хэрэгцээ нүүдлийн мал аж ахуйн бий болгосон бүтээгдэхүүн хоёрын хоорондох харьцаа их тогтворгүй байдаг. Энэ нь тодорхой заагаас хэтэрвэл нийгмийн байдал дордох ба энэ нь цаашид үргэлжилбэл мал аж ахуйн нийгэм эдийн засагт үзүүлэх ашиг нь багасаж эхэлдэг. Хүн ам, мал сүрэг төвлөрөх, нэг нутаг, нэг бэлчээрийг удаан хугацаагаар ашиглах нь мөн л сөрөг нөлөө үзүүлдэг.

Хүн ам хэт их өсөх зааг, аятай бүс олширохыг анхаарч үйл ажиллагаа эрхлэх таарамжтай байдлыг тооцоолж болдог. Энэ нь цөөн тооны бүлэг хүмүүс улирлын чанартай мал маллах явдал юм. Гэвч энэ тархай бутархайн хамгийн таарамжтай нөхцөлд байнгын бус бүтээгдэхүүний асуудал гарч ирнэ. Мөн өрсөлдөөн бий болж түүнийг зохицуулах шаардлага ч гарч ирнэ.

тэмцлийг болон ард олны дотор гардаг үймээн самууныг дарах хүч, бас цэрэг дайны бэлтгэлийг найдвартай хангах болон өнчин ядуусыг тэтгэх зэрэгт зориулсан эдийн засгийн тодорхой үйл ажиллагаа явуулдаг байгууллага байсан юм.

Гурав. Монголын улс төрийн бутралын үеийн төрийг тодорхойлохдоо энэ төр улс орныхоо нэгдмэл байдлыг хамгаалагч, манжийн түрэмгийллийг эсэргүүцэгч хүч байсан юм.

Дөрөв. Монгол улсын түүхийн өөр өөр үед төрийн үйл ажиллагааны шинж чанар, зорилтонд тийнхүү зохих ялгаа байсан тулд тэдгээр үе шат бүрийн онцлогынх нь үүднээс Монголын төрийг тодорхойлохдоо төр бол гол үүргийн хувьд ноёрхогч ангиас дарлагдагч олон түмнийг дарангуйлах машин байсан нөхцөл, тохиолдол түүхэнд цөөнгүй дөвийлгөн туйлчлаад зогсохгүй түүхийн тодорхой нөхцөлд түүний гол үүрэг өөр өөр байж болдгийг үгүйсгэдэг хэвшмэл сэтгэлгээнээс салах учиртай.

Монгол улс дахь нүүдлийн соёл иргэншил нь өөрийн гэсэн онцлогтой нөхцөл, өвөрмөц загвараар хөгжиж ирсэн боловч суурин соёл иргэншлийн нэгэн адилаар эцсийн эцэст хүн амын өөрчлөгдөн буй хэрэгцээг хангахад чиглэгдэж иржээ. Монголын нүүдэлчид нь нийгмийн хэрэгцээ, нийгэмд байж болох баялгийн хоорондох харьцааг хамгийн тааламжтай болгох үйл явцыг түүхийнхээ бүхий үйл явцад хэрэгжүүлж ирсэн гэж хэлж болно. Монгол дахь нүүдлийн соёл иргэншил нь адгуусан амьтанг гэрийн болгосон цагаас нүүдлийн мал аж ахуй жинхэнэ утгаараа төлөвших хүртлээ байгаль орчин дасан зохицох үйл явцыг тасралтгүй хэрэгжүүлсээр ирсэн гэж хэлж болно.

Монголын нүүдлийн соёл иргэншлийн үндсэн хэв шинж нь эх газрын эрс тэс уур амьсгалд зохицож ирснээс гадна байгалийн байнгын өөрчлөлт, түүний экологийн үр дагаварт илүү зохицсон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Энэ зохицолт нь Монголын нүүдлийн соёл иргэншил дэх төрийн түүхэн хөгжлийн бодит байдлыг ойлгон судлахад хамгийн гол судалгааны хэрэглэгдэхүүн болох бөгөөд сэрүүн уур амьсгалтай бүсүүдийн суурин нийгэмтэй Монголын нүүдлийн соёл иргэншлийн үйл явцыг махчилан харьцуулж болохгүй гэдэг нь ойлгомжтой.

Экологийн үүднээс хамгийн таарамжтай олон тооны тархай бутархай аж ахуйнууд мал сүргийг нэг төрлөөр дагнахгүй олон талын ашигтай мал аж ахуйн шаардлагын янз бүрийн илрэлүүдтэй хослуулах байдал юм. Гэхдээ хүн амын хэрэгцээ нүүдлийн мал аж ахуйн бий болгосон бүтээгдэхүүн хоёрын хоорондох харьцаа их тогтворгүй байдаг. Энэ нь тодорхой заагаас хэтэрвэл нийгмийн байдал дордох ба энэ нь цаашид үргэлжилбэл мал аж ахуйн нийгэм эдийн засагт үзүүлэх ашиг нь багасаж эхэлдэг. Хүн ам, мал сүрэг төвлөрөх, нэг нутаг, нэг бэлчээрийг удаан хугацаагаар ашиглах нь мөн л сөрөг нөлөө үзүүлдэг.

Хүн ам хэт их өсөх зааг, аятай бүс олширохыг анхаарч үйл ажиллагаа эрхлэх таарамжтай байдлыг тооцоолж болдог. Энэ нь цөөн тооны бүлэг хүмүүс улирлын чанартай мал маллах явдал юм. Гэвч энэ тархай бутархайн хамгийн таарамжтай нөхцөлд байнгын бус бүтээгдэхүүний асуудал гарч ирнэ. Мөн өрсөлдөөн бий болж түүнийг зохицуулах шаардлага ч гарч ирнэ.

хааны үед хааны удирдлаган дор “цэцдийн зөвлөл”, “их хуралдай” гэсэн зөвлөлүүд хаанд зөвлөх эрхтэй ажиллаж байсан нь төрийг удирдах ардчилсан ёсны тодорхой хэлбэр мөн байв. XVII зууны дунд үе гэхэд буддын шашны хүчтэй нөлөөгөөр цэрэг-захиргааны шинжтэй явж ирсэн төр шашинт төрөөр солигдох нөхцөл бий болсон. Тийм төр 1911 онд Богд хаант Монгол улсад л биелэлээ олсон байна. Богд хаант засгийн газраа байгуулж, сайд нараа томилсон бөгөөд тэд нь Богд гэгээний өмнө хариуцлага хүлээж зөвхөн түүний зарлигаар халагдах, солигдох ёстой байжээ. Түүнээс гадна 1914 оноос эхлэн парламент хэлбэртэй дээд, доод хоёр хурал хааны дэргэд байгуулагдсан нь Богд хаанд зөвхөн зөвлөх эрхтэй байв. Ийнхүү 1921 оны хувьсгалтай золгох хүртэл Монголчууд төвлөрсөн төр засгаар залж жолоодуулж ирсэн түүхтэй. Гэхдээ тэр төвлөрсөн төрөөр залж жолоодуулж ирсэн засаглалын эх үүсвэр нь цөөнхийн сонгуулиар тавигдаж байсан онцлогтой юм. Монголчууд 2000 орчим жилийн турш сонгуулиар эх үүсвэр нь тавигдах замаар бий болсон нэг хүний гарт төвлөрсөн төртэй явж ирсэн нь түүхэн зайлшгүй зүйл байсан гэж хэлж болно. Үүний учир өрнө хийгээд дорнын сэтгэлгээний онцлогийн харьцуулалтыг авч үзвэл дорнын нийгмийн онцлог бол эсрэг, тэсрэг хүчнүүдийн нэгдэл, нягтрал, төвлөрөлд байдаг. Энд нийгмийн амьдралд эсрэг талуудын тэмцлээсээ нэгдэл нь голлох, болох юм шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Энэ бол дорнын тэр тусмаа Монгол үндэстний нөгөө хөндөж өөрчилж үл болох язгуур онцлог хэмээн үзэж болно.

Улс үндэстний төлөөх тэмцэлд гавьяа байгуулсан, хүнд хэцүү нөхцлөөс улс үндэстнээ авч гарч байсан бүх талаараа шалгарч, тодорч гарсан, ард олны дунд асар их нэр хүндтэй хүнээ цөөнхийн сонгуулиар сонгож байсан нь нарийн утга учиртай зүйл байдаг. Ер Монголчууд цөөнхийн сонгууль хийх, угсаа залгамжлах, шашинт төрийн үеэс эхлэн Богд хааны дүр тодруулах ийм аргаар төрийн тэргүүнийг тодруулж байсан уламжлалтай явж ирсэн нь хоцрогдсон, бүдүүлэг харанхуйнх буюу ардчилал хөгжөөгүйнх биш юм.

Төрийг барих асуудлыг зөвөөр шийдвэрлэх нь маш нарийн олон талтай, түүнийг зөвхөн учрыг нь мэдэх энэ талаар мэргэшсэн, боловсорсон хүмүүс эрхлэх учиртай байдаг. Цөөнх гэдэг нь чухамдаа тэр мэргэшсэн, боловсорсон хүмүүс юм. Хүннүгийн үеийн аймгуудын толгойлогчийн, XIII зууны үед мянгатын дарга, Чингисийн удмын ноёдуудын чуулга бүгд л тэр мэргэшсэн, боловсорсон хүмүүсийн чуулга, хурал байв.

Монголчууд түүхэндээ олон удаа бусдын эрхшээлд орж, бусдад уусаж, устаж алга болох аюултай тулгарч байсан боловч, тухай бүр нь түүнээс эсэн мэнд гарч чадаж байсан нь төрийнхөө тэргүүнийг зөв аргаар, зөв хүнээр тавьж, улс төрийн зөв холч, нарийн бодлого явуулж ирсэнтэй нилээд хэмжээгээр холбоотой. Ямар ч үед хөдлөшгүй барьж байсан “хар хайрцаг”-ийн хэмээх төрийн нууц бодлогыг Чингис хааны үеэс явуулж ирсэн түүхтэй. Богд хаант Монгол улсын үед жил бүр ноёдуудын ургийн бичгийн тайлан, түүний шинэчлэлтийг засгийн газраас эрхлэн гаргуулж, хийлгэдэг байжээ. Энэ нь цаанаа улсаа залгамжлуулах мэргэшсэн, боловсорсон, шалгарсан хүмүүсээр төрийг бариулах зорилготой гэдэг нь ойлгомжтой. Бас хүн амаа хэд хэдэн шат

хааны үед хааны удирдлаган дор “цэцдийн зөвлөл”, “их хуралдай” гэсэн зөвлөлүүд хаанд зөвлөх эрхтэй ажиллаж байсан нь төрийг удирдах ардчилсан ёсны тодорхой хэлбэр мөн байв. XVII зууны дунд үе гэхэд буддын шашны хүчтэй нөлөөгөөр цэрэг-захиргааны шинжтэй явж ирсэн төр шашинт төрөөр солигдох нөхцөл бий болсон. Тийм төр 1911 онд Богд хаант Монгол улсад л биелэлээ олсон байна. Богд хаант засгийн газраа байгуулж, сайд нараа томилсон бөгөөд тэд нь Богд гэгээний өмнө хариуцлага хүлээж зөвхөн түүний зарлигаар халагдах, солигдох ёстой байжээ. Түүнээс гадна 1914 оноос эхлэн парламент хэлбэртэй дээд, доод хоёр хурал хааны дэргэд байгуулагдсан нь Богд хаанд зөвхөн зөвлөх эрхтэй байв. Ийнхүү 1921 оны хувьсгалтай золгох хүртэл Монголчууд төвлөрсөн төр засгаар залж жолоодуулж ирсэн түүхтэй. Гэхдээ тэр төвлөрсөн төрөөр залж жолоодуулж ирсэн засаглалын эх үүсвэр нь цөөнхийн сонгуулиар тавигдаж байсан онцлогтой юм. Монголчууд 2000 орчим жилийн турш сонгуулиар эх үүсвэр нь тавигдах замаар бий болсон нэг хүний гарт төвлөрсөн төртэй явж ирсэн нь түүхэн зайлшгүй зүйл байсан гэж хэлж болно. Үүний учир өрнө хийгээд дорнын сэтгэлгээний онцлогийн харьцуулалтыг авч үзвэл дорнын нийгмийн онцлог бол эсрэг, тэсрэг хүчнүүдийн нэгдэл, нягтрал, төвлөрөлд байдаг. Энд нийгмийн амьдралд эсрэг талуудын тэмцлээсээ нэгдэл нь голлох, болох юм шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Энэ бол дорнын тэр тусмаа Монгол үндэстний нөгөө хөндөж өөрчилж үл болох язгуур онцлог хэмээн үзэж болно.

Улс үндэстний төлөөх тэмцэлд гавьяа байгуулсан, хүнд хэцүү нөхцлөөс улс үндэстнээ авч гарч байсан бүх талаараа шалгарч, тодорч гарсан, ард олны дунд асар их нэр хүндтэй хүнээ цөөнхийн сонгуулиар сонгож байсан нь нарийн утга учиртай зүйл байдаг. Ер Монголчууд цөөнхийн сонгууль хийх, угсаа залгамжлах, шашинт төрийн үеэс эхлэн Богд хааны дүр тодруулах ийм аргаар төрийн тэргүүнийг тодруулж байсан уламжлалтай явж ирсэн нь хоцрогдсон, бүдүүлэг харанхуйнх буюу ардчилал хөгжөөгүйнх биш юм.

Төрийг барих асуудлыг зөвөөр шийдвэрлэх нь маш нарийн олон талтай, түүнийг зөвхөн учрыг нь мэдэх энэ талаар мэргэшсэн, боловсорсон хүмүүс эрхлэх учиртай байдаг. Цөөнх гэдэг нь чухамдаа тэр мэргэшсэн, боловсорсон хүмүүс юм. Хүннүгийн үеийн аймгуудын толгойлогчийн, XIII зууны үед мянгатын дарга, Чингисийн удмын ноёдуудын чуулга бүгд л тэр мэргэжсэн, боловсорсон хүмүүсийн чуулга, хурал байв.

Монголчууд түүхэндээ олон удаа бусдын эрхшээлд орж, бусдад уусаж, устаж алга болох аюултай тулгарч байсан боловч, тухай бүр нь түүнээс эсэн мэнд гарч чадаж байсан нь төрийнхөө тэргүүнийг зөв аргаар, зөв хүнээр тавьж, улс төрийн зөв холч, нарийн бодлого явуулж ирсэнтэй нилээд хэмжээгээр холбоотой. Ямар ч үед хөдлөшгүй барьж байсан “хар хайрцаг”-ийн хэмээх төрийн нууц бодлогыг Чингис хааны үеэс явуулж ирсэн түүхтэй. Богд хаант Монгол улсын үед жил бүр ноёдуудын ургийн бичгийн тайлан, түүний шинэчлэлтийг засгийн газраас эрхлэн гаргуулж, хийлгэдэг байжээ. Энэ нь цаанаа улсаа залгамжлуулах мэргэшсэн, боловсорсон, шалгарсан хүмүүсээр төрийг бариулах зорилготой гэдэг нь ойлгомжтой. Бас хүн амаа хэд хэдэн шат

бүхий зэрэг дэв болгон хуваан захирч ирсэн нь Монгол төрийн өвөрмөц онцлог болно.

“Дорно дахинд нэг хүн эрх чөлөөтэй, тэр нь төрийн тэргүүн, дорно дахины хүмүүс захирагч хэмээх төвөө тойрон хүрээлсэн байдаг, тэрхүү захирагч нь Римийн эзэн хаан лугаа дарангуйлагч биш, овгийн ахлагч адил хүндэтгэлтэй хүн юм¹⁵²” хэмээн Германы философич Г.Гегель тэмдэглэсэн байдаг. Ингэхлээр хоёр янзын захирагч байхнээ, нэг нь дарангуйлагч, нөгөө нь ганцаараа ноёрхогчын хувьд эхнийхтэй адил хүндтэй, олон түмнээр хүрээлүүлж чадсан захирагч, удирдагч, бүх утгаараа улсын тэргүүн байх юм.

1990-ээд оноос хойш манай орчлон ертөнцөд олон зүйл байр сууринаасаа хөдөлж нийтлэг нэг хэв шинж рүү орсон нь эдүгээ яриад байгаа зах зээлийн харилцаат хүмүүнлэг ардчилсан тогтолцоо юм. Иймээс өнөө үед манай нийгмийн харилцааны бүхий л тал зүйлийг хамаарсан эрс өөрчлөлтүүд гаднаас хүч түрэн орж ирж байгаа даяарчиллын давалгаа, зах зээлийн эдийн засгийн хөгжил нь нийгмийн бүх салбарт мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байна.

Түлхүүр үг: Төр, Монгол төр, төрт ёсны уламжлал, ардчилал, тэнгэр, Чингис хаан, төр улс, Монголын нууц товчоо, ардчилал, Монгол төрийн түүхэн уламжлал, бөөгийн шашин, нүүдэлчид, нүүдийн соёл иргэншил

Товч хураангуй: Тухайн өгүүлийн хүрээнд Монгол төрийн түүхэн хөгжлийн үйл явц дахь ардчиллын зарим нэг илрэлүүдийг тусгасан. Түүнчлэн Монгол төрийн уламжлалт зохион байгуулалт, бүтцийн зарим нэг дэвшилтэт хүчин зүйлсийг Монголчуудын сэтгэлгээний онцлогтой уялдуулан илэрхийлэхийг зорьсон болно.

ABSTRACT

Some representation evidence in the Mongolian historical state development process was defined. Also some advanced factors of the Mongolian state organization and structure were stated according to the Mongolians mentality.

¹⁵² Гегель Г, Философия истории, СПб., 1993, стр 148-149

НОМ ЗҮЙ

Нэг. Монгол хэл дээр:

1. Ардын заргын бичиг, Улаанбаатар, 1966.
2. Жүгдэр Ч. Монголын нийгэм- улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн түүхэн тойм, Улаанбаатар, 2005.
3. Инжинаш В, Хөх судар, Тэргүүн дэвтэр, Хөх хот, 1992
4. Очир А, Чулуунжав Д, Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил, Улаанбаатар, 1995.
5. Хавх Н, Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан, Улаанбаатар, 1997.
6. Хайссаг В, Монголын түүх ба соёл, Хөх хот, 1992.
7. Лувсанчойндон, Монгол зан үйлийн ойлбор, Хөх хот, 1981
8. Монголын нууц товчоо, Улаанбаатар, 1966.
9. Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил, 1-2 боть, Улаанбаатар, 1995.
10. Монголын философийн түүх, Улаанбаатар, 1997.
11. Монголын түүх, 1,2,3,4,5 боть, Улаанбаатар, 2003.
12. Рашид ад дин, Судрын чуулган, Улаанбаатар, 1998, (Х.Ширчингийн орчуулга)
13. Поздняков Э,А, Улс төрийн философи, Улаанбаатар, 2004.

Хоёр. Орос хэл дээр:

1. Барулин В, С, Социальная философия М., 1999.
2. Гегель Г, Энциклопедия философских наук, М., 1975.
3. Гегель Г, Философия истории, СПб., 1993.